

Хүннүгийн бичиг соёлын асуудалд

З.Батсайхан

Хүннү нарын хэл ба бичиг үсгийн тухай сэдэв бол олон маргаантай асуудлуудын нэг мөн бөгөөд судлан шинжлэх ажил үргэлжилж зарим талаар тодорхой ахиц дэвшил гарахын зэрэгцээ хүннүгийн бичиг соёлд холбогдох шинэ хэрэглэгдэхүүн олдсоор байна. Гэвч хүннү нар чухам ямар бичиг үсэг хэрэглэж байсан тухай асуудал хараахан нэг мөр болоогүй боловч бичигтэй байсан гэх санал давамгайлсаар байгаа ба хүннүгийн нийгэм нэгэнт бичиг үсэг хэрэглэх хэмжээнд хүрсэн байжээ. Нөгөө талаар эртний хятад сурвалжууд хүннү нар бичиг үсэгтэй байсныг огт үгүйсгээгүй, харин тэд бусад улс оронтой захидал зангаагаар харилцсан тухай түүхэн тэмдэглэлүүд сурвалжид цөөнгүй байна.

Хүннүгийн бичиг үсгийн асуудлыг шинжлэн нягталсан судлаачид тэднийг руни бичигтэй байсан гэдэг санал давамгайлдаг бөгөөд (Доржсүрэн 1961, Сүхбаатар 1967) мөнхүү руни бичгийг Төв Азид төр улсаа удаа дараалан байгуулсан сяньби, тоба, жужан нар хэрэглэж байсан ба (Сүхбаатар 1967, Rona Tas 1965) ба VIII зууны үед хятан нар мод сийлэн тэмдэглэх бичигтэй болсон нь мөнөөх л руни бичгийг хэлсэн бололтой.

Руни бичгийн гарал үүслийг бүр XIX зууны үеэс судлаж түүнийг эртний овгийн тамга тэмдэг лугаа холбон үзжээ (Аристов 1894, Спасский 1825). Ялангуяа, Х.Пэрлээгийн "Монгол түмний гаралыг тамгаар хайж судлах нь" гэдэг нэгэн сэдэвт зохиол нь зөвхөн тамга төдийгүй, монгол нутаг дахь нүүдэлчдийн бичиг соёлын үүслийг лавшруулан судлах чухал хэрэглэгдэхүүн болжээ (1976).

Ц.Шагдарсүрэн тамга тэмдгийн зүйлийг орхон, енисейн руни бичигтэй харьцуулан судлаж басхүү Халуун гол, Чэндэгийн хүрэл хутганы тэмдэгийг оролцуулан 60 гаруйг бүртгэж төв Азийн нүүдэлчдийн бичиг үсэг гэж үзсэн бөгөөд хожмын бүтээлдээ тухайн үед нийтлэг хэрэглэгдэж байсан тамга маягийн бичиг бололтой гээд хүн төрөлхтөний хөгжлийн үлэмжхэн түрүү шатанд мод, чулуу тэргүүтэн дээр бичиж тэмдэглэхэд тохирсон шулуундуу зураас маягийн хялбархан дүрстэй үүсч

Ази, Европт нийтлэг хэрэглэгдсээр МЭ-ний IX зууныг хүргэсэн гэжээ (1992,2002).

Буриадын судлаач С.Ш.Чагдуров кэму хэмээх эртний нүүдэлчдийн бичиг соёлд холбогдох үгийг хэл шинжлэлийн талаас нь судлаж өвөг монгол хэлний үг гэж үзээд орчин цагийн монгол төрөл хэлүүдэд хэв гэдэг хэлбэрээр хадгалагдсан хутгаар сийлж бичдэг бичиг гэсэн агуулга илэрхий байна гэжээ (1983:56-68).

Дээрх судлаачдын бүтээлүүдэд хүннү нар тамга маягийн бичигтэй гэдэгт санал нэгдэж буй нь илэрхий байгаа боловч эргэн нягтлан үзэх асуудал бий. Өнгөрсөн зууны хориод оны дундуураас эхлэн Хараагийн Ноён уулын хүннүгийн ихэс язгууртнуудын булш бунханг малтан шинжлэх явцад олдсон шавар сав суулга болон чий будагтай аяганы ёроолд тамга тэмдгийн зүйл сийлсэн байсан нь судлаачдын анхаарлын гадуур өнгөрсөнгүй. Түүнээс хойш монгол орныг археологийн талаар нилээд эрчимтэй судлаж эртний нүүдэлчдийн түүх, соёлыг нэхэн хэлэлцэх шинэ хэрэглэгдэхүүн хуримтлагдаж эхэлсэн бөгөөд тэдгээрийн дотор хүннү нарт холбогдох тамга тэмдэг цөөнгүй байсныг түүхч А.Дамдинсүрэн нэгтгэн 14-ийн зэрэгт хүргэж тэр тухайгаа нэгэн өгүүлэл болгон нийтлүүлсэн (1972:99-111) бол ерээд оны эхээр шинээр илэрсэн 11 тамга тэмдэгийг нэмж 25 (Цэвээндорж 1990:119), дараа нь 30 хүргэн "андуурлыг аривтгажээ" (Батсайхан 1994). Эдгээр судлаачдын гаргасан нийтлэг гол алдаа нь А.Дамдинсүрэнгийн тамга тэмдэгийн эмхэтгэлийг нягтлан үзэлгүйгээр аялдан дагасан оршино. Түүний эмхэтгэлд орсон 14 тамганы лавтайяа 6 нь хакас болон таштыкийн дурсгалаас илэрсэн бөгөөд тэрээр хүннүд холбогдож магадгүй хэмээн эргэлзсэн байдлаар оруулсныг нь огт анзаараагүй ажээ.

Иймд уг алдааг дахин давтахгүйн тулд зөвхөн хүннүгийн дурсгалаас илэрсэн тамга тэмдгийг үндсэн сурвалж болгон авч үзвэл эдүгээ 27-ийн зэрэгт хүрч байгаа бөгөөд гагцхүү, тэдгээрийг үнэн зөв хуулбарлах нь нэн чухал асуудал бөгөөд зарим бүтээлд анхны эхээс ихээхэн гажуудуулан хуулсан жишээ цөөнгүй тохиолдож байна.

Судлаачдын үзэж байгаагаар хүннү нар тамга бичигтэй байсан, түүнийг нь түргүүд уламжлан авч сайжруулсан гэдгийн цаана орхон, енисейн руни бичгийг хүннү нар бие даан зохион бүтээсэн гэх санаа цухалзаж байгаа боловч харьцангуй сүүлийн үеийн судалгаагаар руни бичиг эртний Согдийн бичиг үсэгтэй холбоотой болохын баталгаа лам бүр лавширсаар байгаа ажээ (Шагдарсүрэн 2001:17). Тухайн үед согодуудтай ойр дөт оршин сууж байсан хүннүгийн хараат баруун хөршүүд тамга буюу руни маягийн бичиг үсгийг хэрэглэж байсан нь археологийн бодит хэрэглэгдэхүүн бий. Энд юуны өмнө Иссикийн булшнаас гарсан бичээс бүхий мөнгөн аяга, мөн Долоон голын усунийн үеийн Каратомийн булшнаас үг тусгаарлагч бүхий 4 тэмдэгтээс бүтсэн бичээстэй тахилгын зориулалтын бололтой бяцхан чулуун аяга олдсон бөгөөд текст дэх тэмдэгийн давтамж, тусгаарлагч тэмдэг зэрэг нь бичиг үсгийн шинжтэй байгаа юм.

Түүнчлэн МЭ III-Ү зууны Актасын булшнаас 30 гаруй тэмдэгтэй, засаагүй 3 талт чулуун дээр бичсэн бичээс олдсон бөгөөд янз бүрийн мөрүүдэд нэг тэмдэгт давтагдах зэрэг цагаан толгойн үсгийн гол зүйл

тогтол ажиглагдсан байна. Ийнхүү Дорнод Долоон голын янз бүрийн цаг үед холбогдох бичгийн дурсгалд үндэслээд И.М.Дьяконова, В.А.Левшиц, С.Г.Кляшторный нар МЭӨ I мянганы дунд үеэс эхлээд Долоон голын сакууд бичиг үсэг хэрэглэх болсон нь (История Каз.СССР,1977:219) аж ахуй соёлын хувьд ойр төстэй дорнод хөрш хүннү нарт нөлөөлж түүнийг өөрсдийн хэл аялгуунд тохируулан шууд авч хэрэглэсэн байж болох талтай. Ер нь бичиг үсэг мэт тив дэлхийн шинжтэй соёлын томоохон ололт дэвшил нь зөвхөн тухайн ард түмэн төдийгүй ахуй, соёл, шүтлэг бишрэлээрээ ижил төстэй нэг хэсэг ард түмний хүртээл болдог чухал тогтолцоо ажээ.

Эгийн голын Бурхан толгойн 26,28-р булшнаас захаараа хар толботой, билүүдэж зассан хоёр ижил нимгэн хавтгай чулуу гарсаныг Луврын музейн лабораторит шинжлүүлэхэд хятад хар бэх болохыг тогтоосон байна (Эрдэнэбаатар нар 1999:65).

Хятадад, бэхийг чухам хэдийнээс эхлэн хэрэглэж ирсэн нь маргаантай байдаг боловч Чжаньго улсын үеийн хулсан савхан дээрх бичээсийг бэхээр бичсэн байжээ. Хан улсын үед чулуун нүүрс болон нарсны хөвөөгөөр хоёр төрлийн бэх хийж хэрэглэж байснаас гадна бичгийн уламжлалт хэрэглэлд өөрчлөлт гарсан нь юуны бичгийн шинэ хэрэглэл цаас бий болсонгой холбоотой байжээ.

Янтай хэдийгээр хятад гаралтай эд боловч хүннүгийн янтай нь нэгэн цаг үед зэрэгцэн оршиж сан Хан улсын янтайгаас хэлбэр, хийцээрээ эрс ялгаатай байгаа юм.

Янтай, бийрийн хамт нэгэн бүхэл бичгийн хэрэглэл болно. Иймээс, хүннү нар бийрээр бичиг тэмдэглэл хийж байсан нь ойлгомжтой авч чухам ямар гэдэгт бид хариулж чадахгүй. Харин, Чжаньго улсын булшнаас туулайн үстэй 18.5 см урт, 0.4 см бүдүүн хулсан бийр гарсанаас хойш Хан улсын хэд хэдэн булшнаас бийр болон бичгийн хэрэглэл гарч байжээ. Хангийн үед туулайн үсэн бийрийг ихэд эрхэмлэдэг байсан байна (Крюков нар 1983:237-240).

Ийнхүү хүннү нар ямар нэг бичиг үсгийн тогтолцоог хэрэглэж түүгээр гадаад улс оронтой харилцах төдийгүй дотооддоо албан хэргийг бичиглэн хөтлөж байжээ гэх үндэстэй байна. Түүнчлэн, тухайн үеийн дэлхий нийтийн чанартай соёлын ололт амжилт болох бийр, бэх, янтай, торго цаас гэх мэт бичгийн хэрэглэлийг ашиглахын зэрэгцээ заримыг нь тохирох материалаар өөрсдөө хийдэг байжээ.

Ашигласан ном

1. Аристов Н.А. Опыт выяснения этнического состава киргиз-казахов Большой орды и каракиргизов.-ЖС..1984.
2. Батсайхан З. Сүннүгийн "Кему бичиг" түүний холбогдол /туршиц судалгаа/ АС. Т. ХИҮ. УБ. 1994.
3. Доржсүрэн Ц. Умард хүннү. УБ.1961
4. Дамдинсүрэн А. Археологийн шинжилгээгээр олдсон хүннүгийн бичгийн дурсгал. S.A, т. Y, УБ, 1972
5. История Казахской ССР. т. I, Алма-Ата. 1977

6. Крюков М.В, Переломов Л.С, Софронов М.В, Чебоксаров Н.Н. Древние китайцы в эпоху централизованных империй. М., 1983
7. Х. Пэрлээ. Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь. УБ., 1976.
8. Спасский Л.Н. Восточная библиография.-АВ. кн.4. 1825
9. Сүхбаатар Г. Хүннү бичигтэй байсан тухай. ШУАМ, 1967, №2, х.73-81
10. Цэвээндорж Д. Эрдели И. Худгийн толгой, Солби уул, Наймаа толгойн хүннү булш. ТС. №24. УБ. 1990
1. Чагдуров С.Ш. Эпические формулы хэб и символы культа предков зураг.-В кн.: Историко-культурные связи народов Центральной Азии. -Улан-Удэ, 1983, х.56-58
2. Шагдарсүрэн Ц. Монголчуудын үсэг бичгийн товчоон. УБ. 2001
3. Эрдэнэбат. У, Амартүвшин. Ч, Ханичарж В. Эгийн голын сав нутагт шинээр олдсон хоёр суурин. АС. т. XIX, УБ., 1999
4. Rona Tas. Some notes on the terminology of Mongolian writing.-Acta Orientali, t.VIII,1965,

Хүннүд баттай холбогдох тамга тэмдгүүд

Ноён уул		Архангай		Сүхбаатар	
Баруун дөрөөгийн хэрэм					
Дархан					
				Өвөр байгаль	
					
		Өвөрхангай			
		Хангай			
		Говь-Алтай			